



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/224

Номгон

Г

Г

Улсын аварга шалгаруулах Өсвөрийн 16
насны сагсан бөмбөгийн тэмцээнийг Баянхонгор
аймагт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1.6, 13.1.9, Аймгийг хөгжүүлэх 2026-2030 оны үндсэн чиглэлийн 1.2.2.2, Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын аварга шалгаруулах Өсвөрийн 16 насны сагсан бөмбөгийн тэмцээнийг Баянхонгор аймагт 05 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2.Тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, бэлтгэл ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, тэмцээнд шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчид, улсын шүүгчдийг угтах, үдэх, тэмцээний нээлт, хаалтын шагнал гардуулах үйл ажиллагааг өндөр түвшинд төгөлдөр зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Э.Ганзориг), Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг), Биеийн тамир, спортын газар (Б.Хүрэлчулуун) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тэмцээний тайланг 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Ажлын хэсгийн ахлагч (Э.Ганзориг)-д тайлагнаж ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Б.Хүрэлчулуун)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010593

Аймгийн Засаг даргын 2022 оны 21 дүгээр
сарын 12-ний өдрийн 4228 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Ганзориг

Аймгийн Засаг даргын Зөвлөх

Гишүүд:

В.Наранчимэг

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Т.Цэвээндорж

Цагдаагийн газрын дарга

Д.Бат-Эрдэнэ

Онцгой байдлын газрын дарга

Л.Аюурзана

Боловсролын газрын дарга

Н.Мэндбаяр

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

Б.Пүрэвдагва

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга

Г.Лхагва-Очир

Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Бямбасүрэн

Нэгдсэн эмнэлгийн дарга

Б.Хүрэлчулуун

Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Батцэрэн

Авто тээврийн газрын дарга (Баянхонгор Тээвэрчин хоршоо)

М.Насанбат

Баянхонгор сумын Засаг дарга

Ц.Алтанцэцэг

Хөгжимт драмын театрын дарга

Ж.Батболд

Хүүхдийн Тэмүжин театрын дарга

Б.Соронзонбаатар

Чандмань Баянхонгор ХХК-ийн захирал

Ж.Уламбаяр

Баянхонгор Эрчим хүч ЦТХХК-ийн захирал

Г.Энхсайхан

Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтан

Я.Дамдинсүрэн

Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтан

Монголын сагсан бөмбөгийн холбоо

Б.Тэмүүлэн

Баянхонгор аймгийн Сагсан бөмбөгийн холбооны нарийн бичгийн дарга

С.Энхбаяр

Баянхонгор аймгийн Сагсан бөмбөгийн холбооны тэргүүлэгч


Нарийн бичгийн дарга:

Б.Лхаасүрэн

Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2023 оны 22 дүгээр
сарын 29-ний өдрийн 4/322 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт



**УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ӨСВӨРИЙН 16 НАСНЫ САГСАН БӨМБӨГИЙН
ТЭМЦЭЭНИЙГ БАЯНХОНГОР АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Бэлтгэл ажил	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Холбоо барих
1	2	3	4	5	6
1	УАШТ зохион байгуулах захирамж албажуулах, ажлын хэсгийг байгуулж, шуурхай хурлыг тухай бүр зохион байгуулах, үүрэг чиглэл өгөх, хяналт тавих	IV/10-V/15	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Биеийн тамир, спортын газар	-
2	Тэмцээний бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангаж, тайлагнах	IV/10-V/20	Нийгмийн бодлогын хэлтэс	Биеийн тамир, спортын газар	99506756
3	Тэмцээнд оролцогчдын сайн дурын даатгал, халдвар хамгааллын дэглэм сахих, зөвлөмж мэдээллийг хүргэж ажиллах, улсын байцаагч ажиллуулах	Тэмцээний турш	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	Биеийн тамир, спортын газар	-
4	Тэмцээний туршид эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг зохион байгуулах, аврах баг, халдвар хамгааллыг хариуцах эмч, эмнэлгийн ажилтнуудын хуваарийг гаргаж ажиллуулах	Тэмцээний турш	Эрүүл мэндийн газар	Нэгдсэн эмнэлэг	-
5	Тэмцээний төсвийн дагуу тэмцээн, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг төлөвлөн, тухай бүрд нь шийдвэрлэн олгож, ажлыг шуурхай явуулахаар зохион байгуулах	Тэмцээний турш	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Биеийн тамир, спортын газар	-
6	Тэмцээний байруудад дэг журам, аюулгүй байдал, хэв журмыг хариуцан ажиллах	Тэмцээний турш	Цагдаагийн газар	-	
7	Тэмцээн зохион байгуулагдах заал танхим болон тамирчдын байрлах байршлуудад галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх ажлын зохин байгуулах, хяналт тавих	Тэмцээний турш	Онцгой байдлын газар	-	

1	2	3	4	5	6
8	Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Тэмцээний турш	Хэвлэл, олон нийттэй харилцах алба	-	
9	Тэмцээн, нээлт хаалтын арга хэмжээнүүдийг сурталчлах, шууд дамжуулах	Тэмцээний турш	Хэвлэл, олон нийттэй харилцах алба	-	
10	Раге хуудсуудаар шууд дамжуулалт хийх, сэтгүүлч нарыг томилох, тайлбар хийлгэх	Тэмцээний турш	Хэвлэл, олон нийттэй харилцах алба	-	
11	Тэмцээнийг ивээн тэтгэсэн байгууллага, компаниудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах	Тэмцээний турш	Хэвлэл, олон нийттэй харилцах алба	-	
12	Сагсан бөмбөгийн холбооны 18 шүүгчийн 2 талын зардал, байрлах байр, хоолны зардлын тооцоог гаргах, санал дэвшүүлэх	IV/20	Биеийн тамир, спортын газар	Баянхонгор аймгийн Сагсан бөмбөгийн холбоо	88010601
13	Шагналын мөнгө нэмэх эсэх санал боловсруулах, эцэслэх	IV/20	Баянхонгор аймгийн Сагсан бөмбөгийн холбоо	-	-
14	УАШТ-ийн Техникийн зөвлөгөөнд оролцох , зөвлөмж мэдээлэл, хөтөлбөрийг хүргэх	IV/20	Баянхонгор аймгийн Сагсан бөмбөгийн холбоо		
15	Зөвлөмж мэдээллийг нэгтгэн боловсруулах	IV/20	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	Онцгой байдлын газар	99889266
16	Орон нутгийн өнгө үзэмжийг сайжруулах, хог хаягдлыг цэгцлэх	IV/20	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	-	88112196
17	Тамирчдад аймаг орон нутгаа танилцуулах, автобустай аялал зохион байгуулах	IV/08	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	Авто тээврийн газар Баянхонгор Тээвэрчин хоршоо	88206639
18	Заалнуудад шаардлагатай будаг засварын ажлуудыг хийх, өнгө үзэмжийг сайжруулах	IV/20	Биеийн тамир, спортын газар	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	88010601
19	УАШТ-ийн нээлт, хаалтын хөтөлбөр боловсруулах, орчин бүрдүүлэх	V/05	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	-	-
20	УБ хотоос спортын хөтлөгч оролцуулах	V/05	Баянхонгор аймгийн Сагсан бөмбөгийн холбоо	Биеийн тамир, спортын газар	

1	2	3	4	5	6
21	Туслах шүүгч нарын хоол, ус, ундааг хариуцах	V/05	Боловсролын газар	-	
22	Эмч нарын хоол, ус, ундааг хариуцах	V/05	Онцгой байдлын газар	-	99142333
23	Тэмцээний анос баннер 2 зааланд байрлуулах	V/05	Биеийн тамир, спортын газар	-	
24	Нээлт, хаалтын хөтөлбөрт оролцсон уран бүтээлчид, хүүхдүүдийн ус ундаа бэлтгэх	V/05	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	-	80310138
25	Үйлчилгээнд ажилласан албан хаагчдад урамшуулал олгох	V/20	Биеийн тамир, спортын газар	-	
26	Тэмцээний шууд дамжуулалт	V/08	Биеийн тамир, спортын газар	-	80808898
27	Шүүгчид, баг тамирчдыг угтах	V/08	Аймгийн Засаг даргын Зөвлөх Э.Ганзориг Боловсролын газар Л.Аюурзана М.Угтахбаяр	Биеийн тамир, спортын газар	
28	Шүүгчид, багш дасгалжуулагчдын хүлээн авалтыг зохион байгуулах	V/08	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Биеийн тамир, спортын газар	
29	Тамирчдын бэлгийг захиалах, гардуулах	V/08	Аймгийн Засаг даргын Тамгын газар Сагсан бөмбөгийн холбоо	Биеийн тамир, спортын газар	
30	Шүүгчдэд дурсгалын медалион захиалах, гардуулах	IV/25	Аймгийн Засаг даргын Тамгын газар Сагсан бөмбөгийн холбоо	Биеийн тамир, спортын газар	
31	Баянхонгор аймагт байрлах боломжтой үнэ төлбөргүй байрны зураг, бодит байдлыг багуудад мэдээлэх, аймгийн буудлуудын мэдээллийг хүргэх	IV/25	Биеийн тамир, спортын газар Соёл урлаг, аялал жуулчлал,	Биеийн тамир, спортын газар	

1	2	3	4	5	6
			залуучуудын газар		
32	Тэмцээний тоглолтын хуваарь, нэгдсэн хөтөлбөрийг гаргах , олон нийтэд мэдээлэх	IV/25	Биеийн тамир, спортын газар Монголын сагсан бөмбөгийн холбоо	Хэвлэл, олон нийттэй харилцах алба	

.....оОо.....